

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДИТ ИЛРЭЛ

Өвөр Монголын өөртөө Засах Орон байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан тус өөртөө засах орны Ардын засгийн газрын дэргэдэх Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгээс "тусгай судалгааны хурал" зохион байгуулав. Хуралд ШУА-ийн Зүүн хойт ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан Л.Бэгзжав "Монгол улс дахь Хятад судлалын өнөөгийн байдал, хөгжлийн төлөв", Өвөр Монголын Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн захирал профессор Цао Жункай, эрдэм шинжилгээний ажилтан Ширэм нар "Монгол улсын эдийн засгийн шилжилтийн үеийн тулгамдсан асуудлууд" гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв. Илтгэлтэй холбогдуулан олон эрдэмтэд үг хэлж, санал шүүмжлэл гаргав. Эрдэм шинжилгээний энэ хурал нь Монгол, Хятадын ижил төрлийн эрдэм шинжилгээний хоёр байгууллагын олон талт хамтын ажиллагааны бодит илрэл боллоо гэж хоёр тал дүгнэжээ.

С.Ариунсанаа